



Photo Credit: The Asia Foundation

Media and Civil Society Strengthening in Mongolia Project

OVERVIEW

USAID and Pact, Inc., through The Asia Foundation, launched the five-year (2023-2028) Media and Civil Society Strengthening (MACCS) in Mongolia project to support citizen participation and public access to information in Mongolia. Implemented in partnership with international consortium partners the International Research and Exchanges Board and Omdena, the project aims to empower local actors to ensure Mongolia's vibrant democracy grows even stronger and more resilient through empowered civic organizations that are supported by a professional, unbiased media.

PROJECT GOALS

ENHANCE ACCESS TO INFORMATION & BOLSTER CITIZEN ENGAGEMENT

The MACSS project plans to implement activities across four key pathways: 1) strengthening civil society capacity; 2) expanding civic space; 3) enhancing investigative journalism and the media; 4) combatting the influence of disinformation. The MACSS will support Mongolian non-governmental organizations – primarily outside of Ulaanbaatar – to strengthen mechanisms for citizens to engage with their local and national governments, an essential element of democracy. In particular, The MACSS will also support initiatives that increase journalists' and media organizations' skills to conduct quality, wide-ranging, publicly accessible reporting, and combat misinformation.

CONSORTIUM PARTNERS

- **The Asia Foundation** (www.asiafoundation.org) is a nonprofit international development organization committed to improving lives and expanding opportunities across Asia and the Pacific. Informed by 70 years of experience and deep local knowledge, our work is focused on governance, climate action, gender equality, education and leadership, inclusive growth, and international cooperation. In Mongolia, since establishing its country office in 1993, The Foundation has worked closely with the Mongolian government, civil society, and the private sector to find solutions to pressing developmental challenges.
- A leader in designing and implementing specialized media programs that support democracy and strengthen the media's role in promoting accountability and good governance, the **International Research and Exchanges Board (IREX)** (www.irex.org) works with partners in more than 100 countries to empower youth, cultivate leaders, strengthen institutions, and extend access to quality education and information. Their work includes reducing corruption, stopping disinformation, and building social trust.
- **Omdena** (www.omdena.com) is the world's largest platform for impact-oriented and community-driven artificial intelligence (AI) and machine learning development with more than 5,000 engineers in 100+ countries and local chapters in more than 50 countries. By establishing local chapters and organizing ideathons and challenges among tech savvy youth and professionals, Omdena will work to develop technology-based solutions for social accountability.





Зургийн эх сурвалж: Азийн сан

Монгол Улсад хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн салбарыг бэхжүүлэх нь

Төслийн ерөнхий мэдээлэл

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр, Пакт олон улсын байгууллагын дор Азийн сан нь Монгол Улсад иргэний оролцоо, олон нийтийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилготой “Монгол Улсад хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн салбарыг бэхжүүлэх нь” (MACSS) төслийг 2023-2028 онд хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн хүрээнд Олон улсын судалгаа, солилцооны хүрээлэн (IREX) болон Олон улсын технологийн Омдэна (Omdena) компанитай хамтран хэвлэл мэдээллийн тэнцвэртэй, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулснаар иргэний оролцоо, олон нийтийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилготой юм.

Төслийн зорилго

Мэдээллийн хүртээмжийг сайжруулах & Иргэний оролцоог дэмжих

MACSS төсөл нь 1) Иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэх; 2) Иргэний нийгмийн орон зайг тэлэх; 3) Эрэн сурвалжлах сэтгүүлзүй болон хэвлэл мэдээллийн салбарыг дэмжих; 4) Хуурамч мэдээллийг бууруулах зэрэг дөрвөн үндсэн чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа хэрэгжүүлэх юм. Тухайлбал, Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй, тэр дундаа орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудад чиглэсэн, иргэд – төр, засаг захиргааны байгууллагуудын харилцан ойлголцох, хамтран ажиллах механизмыг сайжруулах; хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн үр чадварыг сайжруулах, дэмжих, цаашлаад мэдээллийн чанар, олон талт болон хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, хуурамч мэдээллийг ялгах, багасгах чиглэлд ажиллана.

Төслийн хэрэгжүүлэгч байгууллагууд

- **Азийн сан** (www.asiafoundation.org) нь Ази, Номхон далайн орнуудад үйл ажиллагаа хэрэгжүүлдэг ашгийн бус олон улсын хөгжлийн байгууллага юм. Тус байгууллага нь 70 жилийн туршлага, орон нутгийн мэдлэг туршлагад үндэслэн сайн засаглал, уур амьсгалын өөрчлөлт, жендэрийн тэгш байдал, боловсрол ба манлайлал, хүртээмжтэй өсөлт болон олон улсын харилцааны чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна. Тус сан нь Монгол Улсад 1993 онд суурин төлөөлөгчийн газраа байгуулснаас хойш хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж Монгол Улсын Засгийн газар, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг.
- Ардчилал, хариуцлагатай байдал, сайн засаглалыг бэхжүүлэхэд хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хэвлэл мэдээллийн хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг **Олон улсын судалгаа, солилцооны зөвлөл** (www.irex.org) байгууллага нь залуучуудыг чадавхжуулах, манлайлагчдыг хөгжүүлэх, институтийг бэхжүүлэх, чанартай боловсрол, мэдээллийн хүртээмжийг өргөжүүлэх чиглэлээр 100 гаруй орны байгууллагуудтай хамтран ажилладаг. Тус байгууллага нь авлигыг бууруулах, худал мэдээллийг таслан зогсоох, нийгмийн итгэлцлийг бий болгох зэрэг чиглэлд үйл ажиллагаа явуулдаг.
- **Омдэна** (www.omdena.com) нь дэлхийн 50 гаруй оронд өөрийн салбартай, 100 гаруй орны 5000 гаруй инженерүүдтэй хамтран үр дүнд суурилсан, орон нутгийн санаачилгад тулгуурласан хиймэл оюун ухаан (AI) болон машин сургалт хөгжүүлэлтийн дэлхийн хамгийн том платформ юм. Омдэна нь орон нутгийн салбаруудыг байгуулж, технологийн мэдлэгтэй залуучууд, мэргэжилтнүүдийн дунд хакатон, хэлэлцүүлэг, тэмцээнүүдийг зохион байгуулах замаар нийгмийн эргэх холбоог сайжруулах технологид суурилсан шийдлүүдийг боловсруулж ажилладаг.

